

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5.	5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН
АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАТЦЭНГЭЛ ТАНАА

2020.02.27 № 06/639
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалтай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалтай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Санхүүгийн тайланд бидний илрүүлэлтээр дараах алдаа зөрчлүүд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Алдаа зөрчлүүдийг дурдвал цалинг зөрүүтэй тооцож олгосон 3,000.0 мянган төгрөг, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 69,292.8 мянган төгрөг, зардлын дансны ангилал 13,701.1 мянган төгрөг, цахим тайлангийн бүрдэл хангаагүй 24,751.3 мянган төгрөг, анхан шатны баримт бүрдүүлээгүй 2,678.0 мянган төгрөг, авлага дансны үлдэгдэл 75,359.5 мянган төгрөг нийт 188,782.7 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Батцэнгэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, зардлыг зөв ангилан бүртгэх, анхан шатны баримт бүрдүүлэлтийг хангаж ажиллах, авлагыг барагдуулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ийн аудитор Ч.Эрдэнэжав, аудиторын туслах Б.Отгонсүрэн, А.Баярцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өлзийт экаунт аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 21-ний 01/108 өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Монголын дээд боловсролын шинэчлэлийн түүхтэй бөгөөд Азийн бүс нутагт инженер технологийн мэргэжилтний шинэ үеийг бэлтгэх төв байна. Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийг хотхоноор нь хөгжүүлэх зорилго тавин оюутны мэргэжлийн болон хувь хүний хөгжилд онцгой анхаарч тэдэнд шаардлагатай мэдлэгийг эзэмшүүлж, байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж буй орчинд судалж шинжлэх эрмэлзэлтэй, сэтгэн санаачлах, манлайлах чадвартай болгон хөгжүүлэх"-д оршино.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Германы дээд боловсрол, шинжлэх ухааны тэргүүн туршлагыг удирдлага болгож, Монголын соёл, өвд баттай суурилсан байна.
- Сургалт, судалгаа нь бодит хэрэглээнд чиглэсэн, аж үйлдвэрийн түншлэлд түшиглэсэн байх бөгөөд бүтээлч, шүүмжлэлтэй, нээлттэй сэтгэлгээ, манлайллыг хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот "Журам батлах тухай" тогтоол.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 2019 оны 03 сарын 22-ны өдрийн /шинэчилсэн найруулга/
- 2019 оны 08 дүгээр сарын 30-нд тус сургуулийн захирал Н.Дорждэрэмийн томилогдсон хугацаа дууссан шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөж, тус сургуулийн удирдах зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 38 дугаар тогтоолыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар 06-ны өдрийн А/788 тушаалаар баталгаажуулж Б.Батцэнгэлийг захирлаар томилсон.
- 2019 оны 06 дугаар сарын 17-ны захирлын Б/43 тоот тушаалаар ерөнхий нягтлан бодогч Э.Нарангаравыг шинээр томилсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Тус сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "ACOLUOS" программ хангамжийг ашигладаг.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль дотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,420,321.8 мянган төгрөгөөс тооцон 28,406.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь хувь хэмжээг хэвээр авч жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар тооцон 61,913.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,706.6 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээр авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,057.5	4,162.5	1,105.0
Авлага	452,107.7	348,983.5	(103,124.2)
Бараа материал	1,004,494.4	1,052,465.9	47,971.5
Үндсэн хөрөнгө	16,783,928.7	16,979,436.1	195,507.3
Нийт хөрөнгө	18,243,588.3	18,385,047.9	141,459.6
Өр төлбөр		35,699.3	35,699.3
Засгийн газрын оролцоо	18,243,588.3	18,349,348.6	105,760.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,243,588.3	18,385,047.9	141,459.6

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татаас санхүүжилтийн авлага 416,340.8 мянган төгрөг, төлбөрт үйлчилгээний авлага 35,766.9 мянган төгрөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын үлдэгдэл нь лабораторийн 494 нэр төрлийн 901,024.2 мянга, бичиг хэрэг 356 нэр төрлийн 14,443.7 мянга, барилгын засварын 179 нэр төрлийн 11,895.7 мянга, бусад хангамжийн материалын 366 нэр төрлийн 114,549.2 мянган төгрөгийн нийт 1,052,465.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эцэст 61,591.4 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь лабораторийн хичээлүүдийн цаг болон шалгалт нэмэгдсэн, оюутны өвлийн

амралтыг тааруулан хийхээр төлөвлөсөн дотуур байрны засварын ажлын материал жилийн эцсийн шалгалтанд зориулан нөөцөлсөн бичиг хэргийн материалуудыг 2020 оны худалдан авалтын хугацаанаас шалтгаалан оны эхний нөөцийг 2019 оны эцэст худалдан авч бэлтгэсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө 726,184.0 мянган төгрөгөөр өссөн нь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс хандиваар хүлээн авсан нийт 61 нэр төрлийн 619,343.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж нэмэгдсэн. Тайлант онд 38,163.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 35,992.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 24,324.9 мянган төгрөгийн ном болон 5,749.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 104,230.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А-1/3717 тоот тушаалын дагуу 38 нэр төрлийн 49,505.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж хөрөнгөөс хассан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь хичээлийн сургалтын “Метлаб” программыг 2,890.1 мянган төгрөг, архивын “Эйбл систем” программыг 2,820.0 мянган төгрөгөөр нийт 5,710.1 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 545.3 мянган төгрөгөөс шалтгаалсан бол урьдчилж орсон орлогын дансны үлдэгдэл өссөн нь 22 оюутны сургалтын төлбөр болох 35,154.0 мянган төгрөгийг хүлээн авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,349,348.6 мянган төгрөг болж 105,760.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс нь шалтгаалжээ.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн тайлант онд 2,315,074.2 мянган төгрөгийн орлогын төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,330,797.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 2,329,692.1 мянган төгрөгийн зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл нийт 31,261.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 631,145.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн, үндсэн үйл ажиллагааны орлого, 15,722.8 мянган төгрөгөөр давсан нь шинээр суралцагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт урсгал зардалд 2,329,692.1 мянган төгрөг зарцуулж 31,261.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Тайлант онд Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс нийт 6 төслийн хүрээнд 347,971.9 мянган төгрөг, гадаад төсөл хөтөлбөрөөс 17,366.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 10,642.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 288,738.0 мянга, нийт 653,978.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 321,943.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 332,034.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл нийт 13 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 460,609.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 271,826.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 69,292.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 116,139.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон 9,872.6 мянга, программ хангамжийн жилийн хураамжийг хөрөнгөнд бүртгэсэн 3,246.0 мянга, үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн 6,189.0 мянган төгрөг, санхүүгийн тайлангийн бараа материалын тайлан алдаатай 252,518.7, нийт 271,826.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2. Ажилтанд хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийг үндэслэлгүй 3,000.0 мянган төгрөг нэмж олгосон нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй ба Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалт, УСНББОУС 25 стандартын 4(б)-д “Байгууллага болон ажиллагсад эсвэл тэдний төлөөний талуудын хоорондох албан ёсны төлөвлөгөө эсвэл албан ёсны гэрээний дагуу” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндэслэлгүй нэмж олгосон цалин 3,000.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоох.

3. Харьцуулалтын арга хэрэглэлгүй 69,292.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын хавсралтын 2 дахь заалт, УСНББОУС1-ын 29 дүгээр заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Холбогдох хууль, журам зааврыг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн 116,490.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн захирлыг тус сургуулийн удирдах зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 34 тогтоолоор үүрэгт ажлаас нь чөлөөлснийг БСШУСЯ-ны сайдын 2019 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн Б/38 тоот тушаалаар батламжилсан боловч үндэслэлгүй гэж үзэн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасныг хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзнэ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг байршуулж, 100 мэдээллийг хугацаанд нь, 47 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 33,122.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг 50 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Санхүүгийн тайланд бидний илрүүлэлтээр залруулагдаагүй 188,782.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 61,913.8 мянган төгрөгийн материаллаг түвшинээс өндөр боловч өргөн тархаагүй байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Монгол Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулга, тайлагналыг УСНББОУС, түүнд нийцүүлэн холбогдох хууль тогтоомж Сангийн сайдын баталсан заавар журмуудын материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн. “Хязгаарлалттай санал дүгнэлт” өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Худалдан авалт хийхдээ 24,751.3 мянган төгрөгийн цахим Е-баримтын бүрдлийг ханган ажиллаагүй. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг; Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах тухай" тушаалын 6.5 Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримт бүрдүүлэлтийг хангаагүй байх, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжихгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ холбогдох хууль тогтоомж, журмын дагуу татварын цахим системд е баримтыг харилцагч байгууллагуудаар бүрдлийг хангуулж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цахим Е-баримтыг харилцагч байгууллагуудаас шаардаж бүрдлийг хангаж ажиллана.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа ажил үйлчилгээний бусад зардлаас 305.0 мянган төгрөгийн шатахуун, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 13,351.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. Нийт 13,701.1 мянган төгрөгийн зөрчил нь толилуулга ба тодруулга, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангаагүй ба Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Зардлыг ангиллын дагуу бүртгэхгүй байх, хууль, дүрэм журам, тушаал, хэрэгжихгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийг зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврын дагуу зориулалтаар нь зарцуулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бараа үйлчилгээний бусад зардлаас шатахууныг бэлтгэсэн алдааг давтахгүй, харин сургалтын хэрэглэгдэхүүн гэж үзэн хөрөнгө бэлтгэснийг анхаарч бүлэг хооронд шилжүүлэх хүсэлтээр зөвлөмжийг биелүүлэн ажиллана.

3.3. Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Шатах, тослох материал дансны эхний үлдэгдэл бэлтгэн нийлүүлэгчийн үлдэгдлээс 254.7 мянган төгрөгийн зөрүүтэй, шатахууныг шууд зардалд бүртгэсэн 1,825.1 мянга, албан томилолтын зардлын нотлох баримт дутуу 598.2 мянга нийт 2,678.0 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан зөрчил нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн.

3.3.2 Эрсдэл:

Ажил гүйлгээ үнэн зөв бүртгэгдэхгүй байх, хууль тогтоомж, дүрэм журам зөрчигдөх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ хүчин төгөлдөр анхан шатны баримтанд үндэслэн зөв ангилж, данс бүртгэлд бүртгэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч ажиллана.

3.4. Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Жилийн эцэст төлбөрт үйлчилгээний авлага нь 75,359.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д зааснаар “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна

3.4.2 Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх, өр авлага үүсгэлгүй ажиллах төсвийн тухай хууль зөрчигдөх.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Суралцаж байгаа болон төгсөгчдийн сургалтын төлбөрийн тооцоог баталгаажуулан гэрээний үүргийн биелэлтийг хангуулах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,459,659,556.78</u>	<u>1,405,611,918.37</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,057,500.00	4,162,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,057,500.00	4,162,500.00
3121	Төгрөг	3,057,500.00	4,162,500.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,057,500.00	4,162,500.00
33	АВЛАГА	452,107,709.83	348,983,504.42
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		75,359,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	416,340,809.83	272,200,580.50
335	Бусад авлага	35,766,900.00	1,423,423.92
3351	Байгууллагаас авах авлага	35,766,900.00	1,423,423.92
35	БАРАА МАТЕРИАЛ	1,004,494,346.95	1,052,465,913.95
351	Түүхий эд материал	892,677,846.61	901,099,642.61
35110	Тусгай зориулалттай материал	841,311,032.04	901,024,192.61
35111	Тусгай зориулалтын материал-Боловсруулалт	35,610,174.90	
35112	Тусгай зориулалттай материал-Боловсруулалт	3,424,899.17	
35113	Тусгай зориулалтын материал-Боловсруулалт	4,385,450.50	
35130	Эм боох материал	75,450.00	75,450.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,870,840.00	
354	Хангамжийн материал	111,816,500.34	151,366,271.34
35410	Бичиг хэргийн материал	6,154,649.00	14,443,648.00
35420	Аж ахуйн материал		1,167,970.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,814,300.00	6,144,200.00
35440	Түлш, шатах тослох материал		3,165,560.00
35450	Барилгын засварын материал		11,895,700.00
35470	Бусад хангамжийн материал	102,847,551.34	114,549,193.34
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,783,928,706.44</u>	<u>16,979,435,988.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,783,928,706.44	16,979,435,988.31
392	Биет хөрөнгө	14,502,951,355.66	14,695,747,311.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,903,895,633.82	12,735,456,358.82
39202	Хуримтлагдсан элэгдэл		-237,955,755.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	399,310,674.00	399,310,674.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-172,973,147.62	-225,808,726.66
39205	Машин тоног төхөөрөмж	1,072,193,465.35	1,652,261,923.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-638,519,263.97	-720,993,707.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	641,520,040.87	711,320,718.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-306,495,596.38	-370,973,290.56
39209	Зам, гүүрийн байгууламж	102,687,352.50	271,126,627.50
39210	Хуримтлагдсан элэгдэл		-18,315,246.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	319,058,415.00	324,807,415.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-138,635,866.58	-170,624,301.55
39217	Ном	320,909,648.67	346,134,621.67
393	Биет бус хөрөнгө	2,280,977,350.78	2,283,688,677.00
39301	Програм хангамж	16,105,549.81	14,663,502.81
